



ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН ХУУЛЬ /7/

Д/д	Хуулийн нэр	Баталсан онгоо
1.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.
2.	Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.
3.	Үндэсний их баяр наадмын тухай /Шинэчилсэн найруулга/	2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
4.	Хууль зүйн туслалцааны тухай /Шинэчилсэн найруулга/	2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
6.	Зөвшөөрлийн тухай	2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
7.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/	2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан.
8.	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай	2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төслийг эцэслэн батлахаар Байнгын хороонд шилжүүлсэн.

УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ

	Хуулийн төслийн нэр	Өргөн мэдүүлсэн хугацаа
2.	Шүүхийн шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/	2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Хэлэлцэх эсэх 2022.03.24/
3.	Дампуурлын тухай буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Хэлэлцэх эсэх 2022.06.09/
4.	Зарим төрлийн хяналт шалгалтыг түр зогсоох тухай	2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.
5.	Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/	2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Хэлэлцэх эсэх 2022.05.05/
6.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Хэлэлцэх эсэх 2022.05.05/
7.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Хэлэлцэх эсэх 2022.06.17/
8.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Дэмжигдээгүй 2022.07.01/
9.	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай	2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. /Хэлэлцэх эсэх 2022.06.09/
10.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.
11.	Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл	2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр МАНамын бүлгээс завсарлага авч түр хойшлуулсан.

Нийтийн эрх зүйн хүрээнд

Д/д	Хуулийн төслийн нэр	Хуулийн төслийн боловсруулалтын явц
1.	Дотоод хэргийн их сургуулийн тухай хуулийн төсөл;	Хуулийн төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.
2.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;	Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлсэн.
3.	Шүүх байгуулах тухай хуулийн төсөл;	Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд ХЗДХС-ын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 1/316 тоот албан бичгээр УДШ, ШЕЗ-д “Хамтран ажиллах тухай” албан бичгийг дахин хүргүүлээд байна.ШЕЗ-т холбогдож энэ талаар тодруулахад Шүүх байгуулах тухай хуулийн төслийн талаарх судалгаа, тооцоог хийж, үүний үндсэн дээр хуулийн төслийн саналаа боловсруулж дуусган, УДШ-тэй зөвшилцсөний дараа яаманд хүргүүлэхээр дотооддоо ажлын хэсэг байгуулан ажиллаж байна гэсэн мэдээллийг өгсөн болно.
4.	Зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл;	Тус хуулийн хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг ХЗДХС-ын 2022 оны А/73 тоот тушаалаар байгуулж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж, хуулийн төсөлд санал авахаар ШШГЕГ-т цахимаар хүргүүлсэн бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгааг ШШГЕГ-аар хийлгүүлж байгаа болно.
5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай албаны тухай хуулийн төсөл;	
6.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;	Хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулж, холбогдох судалгааг хийж хуулийн төслийг боловсруулж байгаа бөгөөд тус хуулийн төслийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгүүлж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж байна.

Нийтийн эрх зүйн хүрээнд

Д/д	Хуулийн төслийн нэр	Хуулийн төслийн боловсруулалтын явц
7.	Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн тухай	Хуулийн төсөл боловсруулахад шаардлагатай судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулж байна.
8.	Гэрээт харуул хамгаалалтын тухай	Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ХЗДХСайдын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/197 дугаар тушаалаар байгуулан, хуулийн төслийг боловсруулж байна.
9.	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай буюу Олборлох салбарын ил тод байдлын тухай	Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ХЗДХСайдын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар байгуулсан. Үзэл баримтлалыг 4 сайд хамтран батлахаар болж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад хүргүүлсэн.
10.	Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн төслийн боловсруулахад шаардлагатай судалгааг хийж байна.
11.	Үндэсний спортын тухай	Хуулийн төслийн боловсруулахад шаардлагатай судалгааг хийж байна.
12.	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; (Нийтийн албаны тухай)	Хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг хийж байна.
13.	Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;	Хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай судалгааг хийж байна.

Хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн

- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай
- Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай
- Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

- Казиногийн тухай
- Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай
- Бооцоот морин уралдааны тухай

Боловсруулж байгаа

- Гэр бүлийн тухай
- Хөрөнгө оруулалтын тухай
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай
- Иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай
- Арбитрын тухай болон Эвлэрүүлэн зуучлалын тухай
- Арилжаа эрхлэгчдийн тухай
- Хэрэглэгчийн гэрээний тухай

ЗӨВШӨӨРӨЛ

зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахаар олгосон эрх

“Тусгай”

Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад олгоно.

“Энгийн”

Нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа, эсхүл тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх нэмэлт үйл ажиллагаа, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ахуйн хэрэгцээний зориулалтаар ашиглуулахад олгоно.

Нийтлэг харилцааг зохицуулна.

Тухайн зөвшөөрлөөс шалтгаалж онцлог харилцааг хуульдаа тусгах

Энэ хуулиас гадуур задалж, хувааж, нэмж болохгүй.

Олгох, сунгах, хүчингүй болгох харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулахгүй.

Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа мэдээллээр нээлттэй үйлчилнэ.

Зөвшөөрөлтэйгээс бусад бүх төрлийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх боломж нээлттэй болно.



ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хүчин төгөлдөр
болох 2023.01.01

Хуульд заасан бол нарийвчлан зохицуулна.

Энэ хуулийн жагсаалтад нэмэх замаар шинэ зөвшөөрөл бий болгоно.

төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.

дутуу, буруу ирүүлсэн материалыг нөхөн бүрдүүлэх боломж өгөх, нэгэнт өгсөн материалыг дахин шаардахгүй.

Бүх зөвшөөрлийн мэдээлэл ил тод нээлттэй болно. Мэдээллийн сан цахимжина.

Өргөдөл хянан шийдвэрлэх хугацаа, процес нарийн тусгаж шуурхай байдлыг хангана

Сануулах шийтгэлийн төрөл нэмэх

Торгох шийтгэлийг 2 дахин
хөнгөрүүлэх

Торгох шийтгэлийн хэмжээ дээд,
доод хязгаартай болох

Зарим төрлийн зөрчлийг гэмт хэрэгт
тооцох



**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛ**

**2022.04.12
УИХ-д өргөн
мэдүүлсэн**

Баривчлах шийтгэл оногдуулахгүй
байх этгээдийн хүрээг өргөжүүлэх

Зөрчлийн үйлдлүүдийг тодорхой
болгох

Зарим төрлийн зөрчлийг хасаж
төрийн хяналт шалгалтын хүрээнд
шилжүүлэх

Торгох шийтгэл биелүүлээгүй этгээдэд
төрийн зарим үйлчилгээг хязгаарлах



**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ 2001 ОН**

НИЙТ 1600



**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
2022 ОН**

392 Нийт зөвшөөрөл

283 тусгай

139 энгийн

ТУСГАЙ АНГИ



Нийгмийн хор
аюул багатай
зөрчлийг хасаж
төрийн хяналт
шалгалтад
шилжүүлэх



Зарим зөрчлийг
Эрүүгийн хуульд
шилжүүлэн
тусгах



Хэт ерөнхий
заалтуудыг
тодорхой болгох



Давхардсан
зөрчлийн
үйлдлийг
арилгах



Зайлшгүй
шаардлагатай
зарим төрлийн
зөрчлийг
шинээр нэмэх



Практик
шаардлагад
нийцүүлэх

ЖИШЭЭ: Сонгуулийн тухай хууль зөрчих

Хүчин төгөлдөр хуульд

21. Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

25. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

27. Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шинэчилсэн найруулгын төсөлд

19. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол **хүнийг сануулна.**

24. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол **хүнийг сануулна.**

27. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол **хүнийг сануулна.**



	Тусгай зөвшөөрөл	Олгох эрх бүхий этгээд	
1	1.21.газар эзэмших, ашиглах	Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч	
2	1.22.энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	
3	1.23.тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	Тухайн сум, дүүргийн Засаг дарга	
4	1.24.үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	Тухайн сум, дүүргийн Засаг дарга	
5	1.25.элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга	
6	1.26.цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах	Тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны алба	
7	1.27.хоногт 50-100 шоо метр ус ашиглах	Тухайн аймаг, нийслэлийн байгаль орчны алба	
8	7.6.цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	
9	7.7.ерөнхий боловсролын сургууль байгуулах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	
10	7.8.хүүхэд харах үйлчилгээ эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга	
11	8.28.ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглуулах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	
12	8.29.түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	
13	8.30.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	
14	11.12.нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулах	Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	
15	13.8.нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	
16	13.9.сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	
17	13.19.хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	

тусгай

	Тусгай зөвшөөрөл	Олгох эрх бүхий этгээд
18	13.20.өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
19	14.23.цахилгаан үйлдвэрлэх	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
20	14.24.цахилгаан дамжуулах	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
21	14.25.цахилгаан түгээх	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
22	14.26.дулаан үйлдвэрлэх	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
23	14.27.дулаан дамжуулах	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
24	14.28.дулаан түгээх	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
25	14.29.диспетчерийн зохицуулалт хийх	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
26	14.30.цахилгаан импортлох, экспортлох	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
27	14.31.эрчим хүчний барилга байгууламж барих	Улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих бол төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Зохицуулах хороо
28	14.32.эрчим хүчээр зохицуулалттай хангах	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
29	14.33.эрчим хүчээр зохицуулалтгүй хангах	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
	14.34.хийгээр хангах	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн

	Энгийн зөвшөөрөл	Олгох эрх бүхий этгээд
1	1.8.байгалийн ойгоос зулзаган модыг шилжүүлэн суулгах	Тухайн аймаг, нийслэлийн Байгаль орчны газар
2	1.9.газар эзэмших, ашиглах	Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч
3	1.10.агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
4	1.11.амьтныг эзэмших, ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
5	1.12.ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
6	1.13.ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
7	1.14.хоногт 50 шоо метрээс бага ус ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
8	3.3.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
9	4.1.барилга байгууламж барих, өргөтгөх, шугам сүлжээнд холболт хийх зэрэг зайлшгүй шаардлагаар төрийн өмчийн авто замыг сэтлэх, орц, гарц гаргах	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга
10	10.11.зам, түүний ойролцоо болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэх	Тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга
11	11.6.тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч

Шүүхийн харьяаллыг тодорхой
болгох /Эрүүгийн хэргийн шүүх/

Зөрчил шалган шийдвэрлэх
ажиллагааг цахим хэлбэрээр явуулж
болох

Зөрчил шалган шийдвэрлэх
харьяаллыг тодорхой болгох



**ЗӨРЧИЛ ШАЛГАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ**

Зөрчлийн тухай хуулийн ерөнхий
ангийн зохицуулалтад уялдуулах

Сануулах шийтгэл хэрэглэх журам

Зөрчлийн бүртгэл, мэдээллийн
нэгдсэн цахим сан ажиллах

Торгох шийтгэлийн хэмжээг
хөнгөрүүлэх журам



**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**
УИХ-д өргөн мэдүүлсэн.

**Иргэний хуульд заасан
иргэнээс олгох нэг
удаагийн шинжтэй,
эсхүл ашиг олох
зорилгогүй зээлийн
харилцаанаас В2С, С2С
харилцааг ялгаж,
зохицуулах**

- Бичил санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаална.
- Нэгдсэн бүртгэл бий болно.
- Улсын төсөвт төлөх татвар төлөгдөх нөхцөл бүрдэнэ.
- Тодорхой төрлийн гэмт хэрэг буурна.
- Бүртгэлгүйгээр зээл олгох үйл ажиллагааг зогсооно.
- Хууль тогтоомжоос гадуур хүү, алданги тогтоон ашиг олох үйл ажиллагаа хумигдана.



**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ**
(ШСБ, намрын ээлжит
чуулган)

**Дэлхийн банкны судалгаа:
шүүхийн үйл ажиллагааны
чанарын индекс 18-аас 5,5
оноо авсан.**

**15,6 сая төгрөгийн маргаан
шийдвэрлэхэд 374 хоног,
22.9 хувийн зардал**

**Шүүх зээлийн гэрээний
маргааныг шийдвэрлэж
байгаа дундаж хугацаа 6.2
жил, ШШГЕГ-аас
гүйцэтгэсэн хугацааг
оруулаад 16.6 жил байна**

- Шүүхийн үйлчилгээг цаг хугацааны хувьд түргэн шуурхай хүргэнэ.
- Бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэх тусгай зохицуулалтыг бий болгоно.
- Улсын тэмдэгтийн хураамжтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- Иргэн болон захиргааны хэрэг маргааны харьяаллын давхардлыг арилгана.
- Цахим орчинд хийгдэх гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох нөхцөлийг бүрдүүлнэ.



**ИРГЭНИЙ БОЛОН
ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**
(ШСБ, намрын ээлжит
чуулган)

Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл 2022 оны 4-р сарын байдлаар 2,1 их наяд төгрөгийн гүйцэтгэх хуудаснаас 2.0 их наяд төгрөгийн гүйцэтгэх хуудас биелэгдээгүй

- Иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг шүүх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлнэ.
- Урамшуулал тооцох тогтолцоог сэргээнэ.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг түргэсгэнэ.
- Шүүхийн шийдвэр гарцаагүй биелэгдэх нөхцөлийг бүрдүүлнэ.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ



ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

**Гэр бүлийн тухай хуульд
зарчмын шинжтэй
өөрчлөлт ороогүй байна.
Жилд дунджаар гэрлэлт
6.6 хувиар, гэрлэлт
цуцлалт 1.0 хувиар
нэмэгдсэн.**

- Гэрлэлт, гэрлэлт дуусгавар болох нөхцөл, түүнээс үүсэх үр дагаварыг нарийвчлан тооцож зохицуулна.
- Гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрхийн харилцааг дэлгэрүүлж зохицуулна.
- Хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаална.
- Хүүхдийн эд хөрөнгийн зарцуулалтад асуудал тус бүрт нь хязгаарлалт тогтоож, эрхээ шүүхээр хамгаалуулах, төлөөлүүлэх боломжийг зохицуулна.
- Хүйсийн өөрчлөлт гэрлэлтэд үзүүлэх нөлөө, үр дагаварыг зохицуулна.
- Нөхөн үржихүйн аргыг ашиглаж төрсөн хүүхэд, үр дагаварыг зохицуулна.
- Өв залгамжлах эрхийг баталгаажуулна.
- Үрчлэлтийг шүүхээр шийдвэрлэнэ.

Гэрлэгчдийн эрх, үүрэг

ЭРХ

- гэр бүлээ төлөвлөх;
- оршин суух газраа сонгох;
- сурах, ажил, мэргэжлээ сонгох;
- хуваарьт эд хөрөнгөтэй байх;
- эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах түүнээс олсон ашгийг тэгш хүртэх;
- гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах;
- өөрийн хувийн ашиг сонирхол, эд хөрөнгийн асуудлыг бие даан шийдвэрлэх;
- Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу гэм хорыг арилгуулахыг шаардах;
- хүчирхийллээс ангид байх.

ҮНДСЭН ҮҮРЭГ

- бие биеэ, үр хүүхдээ тэжээн тэтгэх, асран халамжлах, харгалзан дэмжих;
- гэр бүлийн бусад гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- эрүүл хүүхэд төрүүлэхэд бэлтгэх, ургийн өсөлт, бойжилтыг тогтмол хянуулах;
- угийн бичиг хөтлөх, өвлүүлэх;
- үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх;
- гэр бүлийн үнэт зүйл, уламжлал, соёл, ёс заншлыг өвлүүлэх, хамгаалах.

ЁС СУРТАХҮҮНИЙ ҮҮРЭГ

- гэр бүлийн хамтын амьдралаа тогтвортой байлгах;
- гэр бүлийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- бие биеэ хүндэтгэх, халамжлах, дэмжин туслах;
- бие биедээ үнэнч байх;

Гэрлэлт дуусгавар болох

Гэрлэлт дуусгавар болох

- Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14.3-т заасны дагуу гэрлэгч хүйсээ өөрчилсөн.

Гэрлэлт шүүхийн журмаар цуцлах

- Шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа тэргүүн ээлжинд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангана.
- Гэрлэлт цуцалснаар хүүхдээ өгсөн хүмүүжүүлэх, асран хамгаалах эцэг, эхийн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй. (**coparentalité зарчим**)
- Шүүх нэхэмжлэлийн шаардлагаас гадна өөрийн санаачилгаар дараах нөхцөлийг хангана:
 - хүүхдийг эцэг, эхийн хэний асрамжид үлдээх,
 - тусдаа амьдрах болсон эцэг, эхийн хүүхэдтэй уулзах хугацаа,
 - тэтгэмжийн хэмжээ, нэмэлт зардал, сургалтын төлбөрийг хариуцах нөхцөл.

Гэрлэлтийн гэрээ

ЭД ХӨРӨНГИЙН БОЛОН АМИНЫ ХАРИЛЦАА

Гэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг тусгаж болно:

- гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгөнөөс ашиг хүртэх, хуваах;
- гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгийг тодорхойлох;
- гэрлэлт дуусгавар болсны дараа гэр бүлийн гишүүдэд ногдох эд хөрөнгө болон хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгийг шилжүүлэх, хамтран өмчлөх, эсхүл хууль тогтоомжид зааснаар өөр нөхцөл тогтоох;
- гэрлэгчид гэрлэлт, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлаллаар шийдвэрлүүлэх;
- гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах;
- хууль тогтоомжоор харшлаагүй гэр бүлийн харилцааны бусад эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа.

Гэрлэлтийн гэрээгээр дараах харилцааг зохицуулахыг хориглоно:

- гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, эрхийн чадамжийг хязгаарласан, эсхүл дордуулсан;
- гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл хөндсөн;
- гэрлэгчид бие биеэ, насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх, сурах эрхийг хангах үүргээс чөлөөлсөн, хязгаарласан;
- эцэг, эх байх эрхийг хязгаарласан, хассан.

Гэрлэгчид гэрлэлтийн гэрээгээр үл хөдлөх эд хөрөнгийн эрх үүсэх, шилжүүлэх, дуусгавар болох, хязгаарлахаар зохицуулсан бол зохих журмын дагуу хөрөнгийн төрлөөс хамаарч Бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох

“Нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болох” гэж Донорын тухай хуулийн 3.1.18-д заасныг ойлгоно.

Гэрлэгчид нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болохоор үр хөврөлийн донор, эсхүл тээгч эмэгтэйтэй гэрээ байгуулсны үндсэн дээр төрсөн хүүхдийн эцэг, эх байна.

Эхнэр, эсхүл нөхөр нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болохоор нөгөө талдаа зөвшөөрөл олгосон бол тухайн хүүхдийн эцэг, эсхүл эхээр шууд тогтооно.

Нөхөн үржихүйн туслах технологийг ашиглах гэрээ байгуулсан гэрлэгчид үр хөврөлийн донорыг эцэг, эхээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй.

Нөхөн үржихүйн туслах технологийг ашиглах гэрээ байгуулсан үр хөврөлийн донор, эсхүл тээгч эмэгтэй өөрийгөө эцэг, эхээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй.

Эцэг, эхийн үүрэг

ҮНДСЭН ҮҮРЭГ

хүүхдийн биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд өсгөн бойжуулах, хоол хүнс, орон байр, хувцас, хичээлийн хэрэгсэл, тоглоом зэрэг сурах, хөгжихөд шаардлагатай зүйлээр хангах;

хүүхдээ асран хамгаалах, харгалзан дэмжих, тэжээн тэтгэх;

төрөлх хэл, бичиг үсэг, суурь боловсрол эзэмшүүлэх; хүүхдийн эд хөрөнгийг хамгаалах, зохистой захиран зарцуулах;

хүчирхийллээс ангид төлөвшүүлэх;

хуульд заасан бусад үүрэг.

ЁС СУРТАХҮҮНИЙ ҮҮРЭГ

хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирох аргаар хүмүүжүүлэх;

хүүхдэдээ гэр бүлийн угийн бичиг өвлүүлэх, цус ойртолтоос үүсэх үр дагаврыг тайлбарлан таниулах;

хүүхдээ эцэг эх, ахмад настныг хүндлэх, хайрлах, бусдыг хүндэтгэх соёлд сургах, ёс суртахуунд төлөвшүүлэх;

авьяас, хүсэл сонирхлыг нь дэмжих;

түүх, соёл, үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх,

байгаль эх дэлхийгээ хайрлах ухамсрыг төлөвшүүлэх;

хүүхэд эрхээ хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах.

Хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эхийн үүрэг

“coparentalité” principle
“frequent, continuing and meaningful contact”

Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдийн оршин суугаа газраас өөр газарт ажиллаж, сурч, амьдарч байгаа, хорих ял эдэлж байгаа, хугацаат цэргийн алба хааж байгаа болон бусад шалтгаанаар эцэг, эхийг энэ хуульд заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл бүртгүүлээгүй хамт амьдарч байсан эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хэн нэгэндээ саад учруулахыг хориглоно.

Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан, гэрлэлтээ бүртгүүлээгүй хамт амьдарч байсан эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ байгуулж болно.

Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээгээр хүүхэдтэй хамт амьдрах эцэг, эсхүл эх, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхдүүдтэй харилцах, тэднийг хүмүүжүүлэхэд хүлээх үүрэг, олгох тэтгэлгийн хэмжээг тохиролцож болно.

Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээгээр хүүхдийн эрх, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохирох, дордуулах нөхцөлийг тохиролцохыг хориглоно.

Эцэг, эх болон хүүхдийн эд хөрөнгийн харилцаа

Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийн хүрээнд ойлгох ба бусад этгээдээс өв залгажилсан хөрөнгө, оюуны өмчлөлийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал, хувийн авъяас, чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасны орлого, төрөөс олгож байгаа үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас зэргийг хамааруулах.

Эцэг, эх, эсхүл хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй (шүүхийн шийдвэргүйгээр) дараах эрхийг эдлэхгүй

- хүүхдийн өв залгамжлагдсан үл эд хөрөнгө болон өөрийн хөдөлмөрөөр олсон эд хөрөнгийг хүүхдийн хэрэгцээнээс гадна захиран зарцуулах, эсхүл өр төлбөр төлөх;
- хүүхдийн нэрийн өмнөөс өв залгамжлалаас татгалзах, болзолтойгоор өвийг хүлээн авах;
- хүүхдийн нэрийн өмнөөс хүүхдийн эд хөрөнгөд хохирол учруулах, хорогдуулах хэлцэл хийх;
- хүүхдийг бэлэг (бэлэглэлийн гэрээ) авахаас татгалзах;



ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ 1999

40 дүгээр зүйл. Тэтгэлгийн хэмжээ

40.1. Хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараахь хэмжээгээр тогтооно:

40.1.1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар;

40.1.2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр

40.4. Гэрлэгчид бие биеэ, түүнчлэн төрөл, садангийн хүнээ тэжээн тэтгэх тэтгэлэг нь тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээнээс багагүй байна.



ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

'reasonably practicable'

Тэтгэлгийн хэмжээ

Хэмжээг сард нэгээс доошгүй удаа тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж аргачлалын дагуу шүүх тогтооно.

Тэтгэлгийн хэмжээ тэтгэлэгч төлөгч орлогын 50 хувиас хэтэрч болохгүй.

Тэтгэлэг тогтоох аргачлалыг Засгийн газар батална.

Тэжээн тэтгэх гэрээгээр зохицуулж болно.

ҮРЧЛЭЛТ

“Үрчлэлт” гэж **шүүхийн** шийдвэрийн дагуу үрчлэн авсан эцэг, эх болон үрчлүүлсэн хүүхдийн хооронд төрсөн эцэг эх, хүүхдийн адил эрх, үүрэг үүсгэхээр иргэний улсын бүртгэлд бүртгүүлснийг ойлгоно.

ДОТООД ҮРЧЛЭЛТ

Хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллана. Үрчлэлийн зөвлөлийн ажиллах журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ГАДААД ҮРЧЛЭЛТ

Харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлтийн зөвлөл ажиллана.

Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын харьяат гэр бүл, иргэнд үрчлүүлэх чиг үүрэг бүхий Үрчлэлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, гадаадын харьяат гэр бүлтэй ярилцлага хийх журмыг харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.



**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН
ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ**
(намрын ээлжит чуулган)



**Дэлхийн банкны судалгаа:
Маргааныг шүүхийн бус
аргаар шийдвэрлэх- муу
дүн авсан.**

- Шүүхийн ачааллийг бууруулж, иргэдийн цаг, хугацаа хөрөнгийн хэмнэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх боломжийг бататгана.
- Эвлэрийн аргаар маргаан шийдвэрлэх төрлийг өргөжүүлнэ.
- Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргаан шийдвэрлэх процессыг нарийвчилна.
- Эвлэрүүлэн зуучлалаар маргааныг цахим хэлбэрээр шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

ДЭЛХИЙН БАНКНЫ “БИЗНЕС ЭРХЛЭХҮЙ”
СУДАЛГАА

“ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ”
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Гэрээнд итгэх
итгэлийг
нэмэгдүүлэх

Хэрэг маргааныг нь түргэн
шуурхай шийдвэрлэх



Бизнес эрхлэгчдийн
ашгийн төлөө зорилгыг
дэмжих

Бизнесийн ёс зүй,
хариуцлагыг төлөвшүүлэх

Бизнес эрхлэгчдийн ажил үүргийн хүрээнд
тогтсон заншил, заншлын хэм хэмжээг
хэрэглэх

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ



БООЦООТ ТААВАР, ХОНЖВОРТ СУГАЛААНЫ ТУХАЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

**Бооцоот
тоглоомын вэбсайтад
бооцоо тавьдаг:**

**агент, зуучлагч
20 гаруй;**

**хэрэглэгч
100 мянга давсан;**

**идэвхтэй хэрэглэгч
15,000-20,000;**

**Монгол Улсаас
сард 10 тэрбум орчим
төгрөг хяналтгүй гардаг.**

/эх сурвалж: албан бус/

- Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх нийтлэг зохицуулалтыг бий болгоно.
- Бооцоот таавар, хонжворт сугалааны хоорондын ялгааг гаргаж, эдгээрт хамаарах тоглоомыг тодорхойлно.
- Бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, үйл ажиллагааг зохицуулна.
- Хяналт тавих механизм/Мөрийтэй тоглоомын Зөвлөл/-ыг бүрдүүлнэ.
- Оролцогчийн эрх ашгийг хамгаална.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ



БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

**2012-2014 оны хооронд:
мориноос унаж яаралтай
тусламж авсан хүүхэд-941
хэвтэн эмчлүүлсэн-605**

**1996-2006 оны хооронд
амь эрсдсэн-17**

**2012-2014
амь эрсдсэн-6**

- Бооцоот уралдааны шинэ төрлийн спорт болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Уралдааныг нийтийн эрх зүйн этгээд зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Унаач 18 насанд хүрсэн мэргэжлийн хүн байна.
- Морин уралдааны оролцогчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаална.
- Өв соёл, түүхэн уламжлалаа сурталчлан таниулна.
- Эдийн засгийн үр өгөөжтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болно.
- Татварын орлого нэмэгдэж, татварын орлогын зохих хувийг нийгэм, соёлын үйл ажиллагаанд зарцуулна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ



КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

**2019 онд Монгол Улсад
577.3 мянган гадаадын
иргэн аялал жуулчлалын
зорилгоор ирсэн.**

**2020 онд 58.9 мянга болж,
өмнөх оны энэ үеэс 90%**

**2021 онд 33.1 мянга,
өмнөх оны мөн үеэс 43.8%
буусан.**

**2022 оны байдлаар
дэлхийн казиногийн зах
зээлийн үнэлгээ
3.61 тэрбум ам.доллар**

- Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтооно.
- Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр 30 жилийн хугацаагаар Засгийн газар олгоно.
- Хөрөнгө оруулалт 300 сая ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.
- Хяналт тавих механизмыг бүрдүүлнэ.
- Монгол Улсын иргэнийг тоглуулахыг хориглоно.
- Төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэнэ.
- Хуульд заасан 4-н байршилд байгуулна.

The background of the image is a dark blue, semi-transparent overlay over a photograph of legal symbols. On the left, a pair of metal scales of justice is visible, with two pans hanging from a central beam. On the right, a wooden gavel lies horizontally, its head resting on a stack of books. The overall scene is dimly lit, with the blue overlay being the most prominent feature.

**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**

